



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2020/80/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
Менежментийн захидал .....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15



  
**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.18 № 78  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520004



**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Х.Дашдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 06-наас 2020 оны 02 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ, байгалийн эко системийн унаган төрхийг хадгалан хамгаалах”-д оршино.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгалийн бус, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд 6 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 327,459.4 мянган төгрөгөөс тооцон 6,549.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,193.3 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос -36,974.3 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	69.5	00.0	00.0
Бараа материал	79,757.4	85,237.9	5,480.5
Үндсэн хөрөнгө	692,216.8	759,781.1	67,564.3
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-156,700.6	-266,650.1	-109,949.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>615,343.2</b>	<b>578,368.9</b>	<b>-36,974.3</b>
Өр төлбөр	106.2	00.0	-106.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	615,237.0	578,368.9	-36,868.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>615,343.2</b>	<b>578,368.9</b>	<b>-36,974.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аймгийн төсвийн хөрөнгөөр гэрэлтүүлгийн ажил хийгдсэний улмаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ. Энэ нь 54,905.2 мянган төгрөг, 12,659.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 578,368.9 мянган төгрөг болж -36,974.3 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн өндөр байгаатай холбоотой байна.

## 2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын хувьд орлогын төлөвлөгөөг 100 хувь давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 280,802.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 280,802.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 280,802.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 270,949.2 мянган төгрөг буюу 96,5 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 370.0 мянган төгрөг, байгаль хамгаалах сангаас 14,970.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нэмэлт төсөв бүрдүүлжээ. Үүнээс тээвэр шатахууны зардалд 370.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 14,970.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж, нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5,306.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 616.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,335.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Цалингийн зардлаас нэг ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийг 616.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

1. Цалингаас суутган тооцсон сахилгын шийтгэлийн 1,335.8 мянган төгрөгийг бичилтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа цалингийн тооцооноос хасаж бүртгэсэн байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журналд ажил гүйлгээг гарсан цаг хугацаагаар нь биш мөнгөөр төлөгдсөн цаг хугацаагаар бүртгэсэн байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 3,353.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй.

## 2.13. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## 2.13. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалтын талаар:

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийсэн нийт худалдан авалтын 9.5 хувь буюу 2,172.9 мянган төгрөгийн худалдан авалтад е-баримтыг хавсаргаагүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтад е-баримтыг хавсаргаж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

2. МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар

2.1. Илрүүлэлт: Дорнод хамгаалалтын захиргааны дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад хот дотор 1,180.8 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газраас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>79,826,951.22</u></b>	<b><u>85,237,899.99</u></b>
33	<b>АВЛАГА</b>	69,500.83	00.00
335	<b>Бусад авлага</b>	69,500.83	00.00
3351	Байгууллагаас авах авлага	69,500.83	00.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	79,757,450.39	85,237,899.99
354	<b>Хангамжийн материал</b>	74,807,450.39	79,647,899.99
35410	Бичиг хэргийн материал	431,000.00	546,500.00
35420	Аж ахуйн материал	2,818,940.68	5,387,040.68
35470	Бусад хангамжийн материал	71,557,509.71	73,714,359.31
35500	Биологийн хөрөнгө	00.00	00.00
35600	Мал амьтад	4,950,000.00	5,590,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>535,516,226.20</u></b>	<b><u>493,130,972.83</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	535,516,226.20	493,130,972.83
391	Газар	00.00	00.00
392	<b>Биет хөрөнгө</b>	500,578,226.20	458,192,972.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	114,454,739.00	169,359,912.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-6,706,761.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	362,543,523.20	362,543,523.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,804,086.86	-153,331,545.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,860,682.63	125,519,830.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,387,527.11	-68,521,818.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,279,148.43	11,279,148.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,540,927.16	-6,672,631.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,540,695.63	55,540,695.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,368,021.56	-30,817,379.52
393	<b>Биет бус хөрөнгө</b>	34,938,000.00	34,938,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,938,000.00	34,938,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>615,343,177.42</u></b>	<b><u>578,368,872.82</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>106,153.79</u></b>	<b><u>00.00</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	106,153.79	00.00
413	<b>Өглөг</b>	106,153.79	00.00
4136	<b>Бусад өглөг</b>	106,153.79	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	106,153.79	00.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>615,237,023.63</u></b>	<b><u>578,368,872.82</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	615,237,023.63	578,368,872.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	143,013,553.48	143,013,553.48
51101	Өмч: - төрийн	143,013,553.48	143,013,553.48
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	381,279,672.13	344,411,521.32
51210	Өмнөх үеийн үр дүн	381,279,672.13	381,279,672.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-36,868,150.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,943,798.02	90,943,798.02
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>615,343,177.42</u></b>	<b><u>578,368,872.82</u></b>

#### 4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>460,913,640.55</b>	<b>372,796,678.58</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>205,939,449.72</b>	<b>77,954,025.58</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	205,939,449.72	77,954,025.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	205,939,449.72	77,954,025.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,552,661.00	1,302,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	200,386,788.72	76,651,225.58
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>254,974,190.83</b>	<b>294,842,653.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	248,761,400.00	279,502,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	248,761,400.00	279,502,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,143,290.00	15,340,453.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,143,290.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,970,453.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	69,500.83	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	69,500.83	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>327,459,424.26</b>	<b>409,664,829.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>327,459,424.26</b>	<b>409,664,829.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	317,880,010.95	399,809,055.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	182,013,420.48	201,587,971.21
210101	Үндсэн цалин	117,695,485.48	130,302,905.21
210102	Нэмэгдэл	31,176,400.00	34,715,696.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,031,400.00	8,058,225.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,110,135.00	28,511,145.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,204,900.00	25,595,688.57
210201	Тэтгэврийн даатгал	15,642,000.00	17,639,460.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,011,800.00	1,943,396.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,480,300.00	1,620,619.41
210204	Ажилгүйдлийн даатгал	370,000.00	372,720.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,700,800.00	4,019,490.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,477,301.00	5,663,943.00
210301	Гэрэл, цахилгаан	1,456,852.00	1,303,064.00
210302	Түлш, халаалт	4,170,158.00	3,187,893.00
210303	Цэвэр, бохир ус	690,291.00	1,172,986.00
210304	Байрны түрээс	160,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,821,764.95	10,792,210.00
210401	Бичиг хэрэг	1,336,400.00	877,690.00
210402	Тээвэр, шатахуун	6,824,090.00	5,271,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,003,030.00	1,139,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,658,244.95	3,503,680.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,232,000.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	2,232,000.00	00.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,030,700.00</b>	<b>7,161,663.40</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	241,100.00	68,716.30
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	4,950,348.10
210604	Урсгал засвар	789,600.00	2,142,599.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,322,500.00</b>	<b>3,922,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,322,500.00	3,922,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,077,980.00</b>	<b>19,690,552.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,323,180.00	18,617,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,200.00	352,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,700.00	248,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	101,700.00	134,700.00
210807	Газрын төлбөр	178,200.00	97,256.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,699,444.52</b>	<b>125,394,526.95</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	467,000.00	15,444,953.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,232,444.52	109,949,573.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,579,413.31</b>	<b>9,855,774.26</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,579,413.31</b>	<b>9,855,774.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,579,413.31	9,855,774.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>133,454,216.29</b>	<b>-36,868,150.81</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21,984,692.94</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	432,076.08	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	21,552,616.86	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-21,984,692.94</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>111,469,523.35</b>	<b>-36,868,150.81</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>260,457,351.00</b>	<b>296,145,453.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,552,661.00</b>	<b>1,302,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,552,661.00</b>	<b>1,302,800.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,552,661.00	1,302,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,552,661.00	1,302,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>254,904,690.00</b>	<b>294,842,653.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>248,761,400.00</b>	<b>279,502,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	248,761,400.00	279,502,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,143,290.00</b>	<b>15,340,453.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,143,290.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,970,453.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>260,457,351.00</b>	<b>296,145,453.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>260,457,351.00</b>	<b>296,145,453.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>250,877,937.69</b>	<b>286,289,678.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,907,266.69	201,694,125.00
210101	Үндсэн цалин	117,589,331.69	130,409,059.00
210102	Нэмэгдэл	30,719,200.00	34,715,696.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,488,600.00	8,058,225.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,110,135.00	28,511,145.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,204,900.00	25,526,187.74
210201	Тэтгэврийн даатгал	14,803,300.00	17,455,147.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,850,500.00	2,025,775.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,480,300.00	1,620,619.41
210204	Ажилгүйдлийн даатгал	370,000.00	405,154.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,700,800.00	4,019,490.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,477,301.00	5,663,943.00
210301	Гэрэл, цахилгаан	1,456,852.00	1,303,064.00
210302	Түлш, халаалт	4,170,158.00	3,187,893.00
210303	Цэвэр, бохир ус	690,291.00	1,172,986.00
210304	Байрны түрээс	160,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,861,690.00	9,285,779.00
210401	Бичиг хэрэг	1,204,600.00	961,579.00
210402	Тээвэр, шатахуун	6,863,490.00	5,179,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,142,100.00	1,139,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	651,500.00	2,005,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,449,800.00	217,800.00
210502	Хоол, хүнс	2,232,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	217,800.00	217,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,058,900.00	2,648,899.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	269,300.00	269,300.00
210604	Урсгал засвар	789,600.00	2,379,599.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,322,500.00	3,922,500.00
210702	Дотоод албан томилолт	3,322,500.00	3,922,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,128,580.00	21,892,992.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,373,780.00	20,820,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,200.00	352,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,700.00	248,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	101,700.00	134,700.00
210807	Газрын төлбөр	178,200.00	97,256.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	467,000.00	15,437,453.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	467,000.00	15,437,453.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,579,413.31</b>	<b>9,855,774.26</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,579,413.31	9,855,774.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,579,413.31	9,855,774.26
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	108,075,553.48	50,655,228.70	269,810,148.78	00.00	428,540,930.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>108,075,553.48</b>	<b>50,655,228.70</b>	<b>269,810,148.78</b>	<b>00.00</b>	<b>428,540,930.96</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	111,469,523.35	00.00	111,469,523.35
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>143,013,553.48</b>	<b>90,943,798.02</b>	<b>381,279,672.13</b>	<b>00.00</b>	<b>615,237,023.63</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>143,013,553.48</b>	<b>90,943,798.02</b>	<b>381,279,672.13</b>	<b>00.00</b>	<b>615,237,023.63</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>143,013,553.48</b>	<b>90,943,798.02</b>	<b>381,279,672.13</b>	<b>00.00</b>	<b>615,237,023.63</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-36,868,150.81	00.00	-36,868,150.81
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>143,013,553.48</b>	<b>90,943,798.02</b>	<b>344,411,521.32</b>	<b>00.00</b>	<b>578,368,872.82</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	280,802,200.00	280,805,000.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	280,802,200.00	280,805,000.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	280,802,200.00	270,949,225.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210,640,100.00	201,694,125.00
210101	Үндсэн цалин	138,006,600.00	130,409,059.00
210102	Нэмэгдэл	34,512,800.00	34,715,696.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,088,600.00	8,058,225.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,032,100.00	28,511,145.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,419,400.00	25,526,187.74
210201	Тэтгэврийн даатгал	17,908,300.00	17,455,147.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,127,800.00	2,025,775.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,702,200.00	1,620,619.41
210204	Ажилгүйдлийн даатгал	425,500.00	405,154.85
210205	Эрүүл мэндийн даатгал	4,255,600.00	4,019,490.52

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,674,900.00	5,663,943.00
210301	Гэрэл, цахилгаан	1,313,100.00	1,303,064.00
210302	Түлш, халаалт	3,188,800.00	3,187,893.00
210303	Цэвэр, бохир ус	1,173,000.00	1,172,986.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,915,800.00	8,915,779.00
210401	Бичиг хэрэг	961,600.00	961,579.00
210402	Тээвэр, шатахуун	4,809,200.00	4,809,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,139,500.00	1,139,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,005,500.00	2,005,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	217,800.00	217,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	217,800.00	217,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,648,900.00	2,648,899.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	269,300.00	269,300.00
210604	Урсгал засвар	2,379,600.00	2,379,599.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,922,500.00	3,922,500.00
210702	Дотоод албан томилолт	3,922,500.00	3,922,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,895,800.00	21,892,992.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,820,000.00	20,820,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	352,400.00	352,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,700.00	248,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134,700.00	134,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	100,000.00	97,256.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	467,000.00	467,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	467,000.00	467,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	280,802,200.00	280,805,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	280,802,200.00	280,805,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	279,502,200.00	279,502,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,300,000.00	1,302,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	1,302,800.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00